



Монголын бизнес форум боллоо

June 5, 2015 [Source: Barilga](#)

Олон улсын хөрөнгө оруулалтын банк /ОУХОБ/ болон Монголын банкуудын холбоо хамтран Монголын бизнес форумыг “Монгол улсын хөгжил ба олон улсын хамтын ажиллагаа” сэдвийн дор 6-р сарын 5-ны өдөр зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Монголын банк санхүү, бизнесийн байгууллагууд болон ОУХОБ-ны гишүүн Болгар, Куба, Чех, Унгар, Словак, Вьетнам улсын банк санхүү, бизнесийн салбарын төлөөлөгчид оролцож Монголын эдийн засгийн хөрөнгө оруулалтын орчин, боломж цаашдын хамтын ажиллагааны талаар хэлэлцсэн юм. Форум нь “Монгол улс дахь санхүүгийн хөгжил, олон улсын хамтын ажиллагаа” мөн “Монголд хөрөнгө оруулах орчин, боломжууд” гэсэн үндсэн хоёр сэдвийн дор өрнөсөн. Монгол банк, Азийн хөгжлийн банк, Евродын сэргээн босголтын банк, Хөгжлийн банк, Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас зочид төлөөлөгчид оролцон өөрсдийн байр сууриа илэрхийлсэн энэхүү арга хэмжээний үеэр Сангийн яам болон ОУХОБ харилцан ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Энэхүү санамж бичигт гарын үсэг зурснаар ОУХОБ-аас дэлхийд ховордсон ан амьтан болох Пержевалскийн тахь, Алтайн хойлог болоод байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын хөгжилд зориулж хөрөнгө оруулалт хийхээр болж байгаа юм.

Дашрамд дурдахад манай улс 1970 онд ОУХОБ-ын гишүүн орон болжээ.